



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар Б/02

Өмнөдэлгэр сум

Д.Отгонжаргалыг ажилд эргүүлэн авах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.3, 61 дүгээр зүйлийн 61.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Доржсүрэнгийн Отгонжаргалын жирэмсэн, амаржсаны амралт дуусгавар болсон тул биологийн багшаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Д.Отгонжаргалын үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (М.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Д.Отгонжаргалыг мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан ажиллуулахыг сургалтын менежер (Ж.Наранцацрал), эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

